

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Банкны холбогдох этгээд болох “Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК-тай Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан нөхцөлийн дагуу буцаах нөхцөлтэй зээлийн багц худалдах, холбогдох гэрээ, хэлцэл байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Банкийг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Randolph S. Kopra
РАНДОЛФ КОПРА